

I-V ангийн унших чадварын агуулгын залгамж холбоо

Анги	1-р анги	2-р анги	3-р анги	4-р анги	5-р анги
УНШИХ ЧАДВАР					
Унших чадварт тавигдах шаардлага уншлагын чанар	Зөв унших	Унших хурдаа нэмж, бусдад ойлгогдохоор зөв, унших	Өгсөн эхийг бусдын дэмжлэгтэй, ойлгож унших	Ойлгон уншиж, уншсанаа бусадтай хуваалцан ярилцах	Ойлгон уншиж, уншсанаа бусадтай хуваалцан ярилцах
Эхийн агуулгыг ойлгосноо харуулах	1.1.а. Өгүүлбэр, эхээс танил биш үгийг олж, утгыг нь таамаглах	2.1.а. Танил биш үгийг сурах бичгийн тайлбараас цагаан толгойн үсгийн дарааллаар үгээ сонгох, утгыг мэдэх	3.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс үсгийн дарааллаар олж, агуулгыг ойлгох	4.1а. Уншсан эх дэх танил биш үгийг тайлбар толь бичгээс олж, агуулгыг ойлгох	5.1а. Эхэд ашигласан зарим үг, хэллэгийг сонгож, эхэд хэрэглэсний учрыг тайлбарлан дүгнэх
	1.1.б. Сурах бичгийн эх, зурагт эх, богино хэмжээтэй хялбар эхийг уншиж агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	2.1б. Уншсан шүлэг, өгүүллэг, үлгэр, зүйр цэцэн үг зэрэг эхийг уншиж, агуулгыг ерөнхийд нь ойлгосноо харуулах	3.1б. Уншсан эх, үлгэр, өгүүллэг, шүлгээс чухал хэсгийг ялгаж, ойлгосноо харуулах	4.1б Уншсан эхийн болон үлгэр, өгүүллэгийн бүтцийн холбоо хамаарлаас гол санааг ойлгосноо харуулах	"5.1.б. Нэг сэдэвтэй хоёр эхийн утгыг харьцуулах замаар эхийн агуулгыг ойлгосноо харуулах 5.1.в.Уншсан жүжгийн гол санааг тайлбарлах"
	1.1.в. Уншсан эхийн үйл явдлыг асуултын дагуу тоочих (эхлээд? дараа нь, эцэст нь?)	2.1.в. Уншсан үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг дарааллын дагуу тоочих	3.1в. Уншсан үлгэр, өгүүллэг дэх баатрын үйл хөдлөлийн учир шалтгааныг тайлбарлах	4.1в. Уншсан эх, үлгэр, өгүүллэгийн бүтцийн хэсгүүдийн учир шалтгааныг тайлбарлах	5.1.г. Уншсан эхийн эхлэл, гол, төгсгөл хэсгүүдийн утгын холбоо хамаарлыг тайлбарлах
				4.1г Шүлэг дэх хоёр зүйлийн ижил төстэй шинжийг харьцуулан адилтган дүрслэлийг тайлбарлах	5.1.д. Эхээс хүншүүлсэн, хэтрүүлсэн дүрслэлийг тайлбарлах замаар үлгэрийн утгыг ойлгосноо харуулах
			3.1г. Эхээс баатрын болон зохиогчийн үгийг ялгах	4.1д. Эхэд ашигласан баримт ба өгүүлэгчийн үзэл бодлыг илэрхийлсэн хэсгийг ялгах	5.1.е. Үлгэрт амьдралын бодит байдлыг тусгасан эс тусгасан шинжээр нь бодит байдал ба уран сэтгэмжийг ялгах
	"1.1.г. Уншсан эхийн баатрын хийсэн зүйлийг тоочих "	2.1.г. Уншсан эхийн баатруудын сайн, муу үйлийг жишээгээр тайлбарлах	3.1д. Уншсан зохиолын баатруудын зан чанарыг эхээс жишээ татаж тайлбарлах	4.1е. Эхийн эхлэл, гол, төгсгөл хэсэгт баатруудын зан чанар, үзэл бодолд гар-сан өөрчлөлтийг харьцуулах	5.1.ж. Уншсан эхийн баатруудын харилцан ярианаас тэдний зан чанарыг дүгнэх
		2.1.д. Талархал, мэндчилгээ, товч анкет, гэр бүлийн танилцуулга, заавар зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	3.1е. Талархсан захидал, зорилгодоо хүрэх төлөвлөгөө, номын тэмдэглэл, хаяг, шошго зэргийг уншиж, агуулга, бүтцийг тайлбарлах	4.1ж. Урилга, уриалга, номын танилцуулга, сонины мэдээ, талархлын захидал зэргийн зорилго, бүтцийг тайлбарлах	5.1з. Захидлаас нэг сэдвийн талаар ялгаатай үзэл бодлыг харьцуулж дүгнэх
	1.1.д. Цээжилсэн хэл зүгш-рүүлэх үг, балгэ дэмбэрлийн үг, шүлгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	2.1.е. Цээжилсэн шүлэг, зугаа үг, хэл зүгшрүүлэх үгийг бусдын өмнө тод чанга дуугаар унших	3.1ж. Цээжилсэн шүлгийн утгыг мэдэрч, мэдрэмжээ илэрхийлэн уран унших	4.1з. Хурд, дууны өнгөө тохируулан урнаар уншиж, шүлгийн утгыг ойлгосноо харуулах	"5.1и. Зохиолчийн санааг мэдэрч, уран унших
Бүтээлчээр ойлгож унших	1.1.е. Зохиолын баатруудын гадаад байдлыг төсөөлөх	2.1.ж. Өгсөн зургаас баатрууд хоорондоо юу ярилцсаныг ургуулан төсөөлөх	"3.1з. Үлгэр, өгүүллэгийн үйл явдлыг уншихдаа гол баатрын хэлэх үгийг ургуулан бодож, төсөөлөх"	"4.1и. Зохиолын баатрын гадаад дүр байдлыг ургуулан бодож төсөөлөх"	5.1к. . Үйл явдал хаана, хэзээ өрнөж байгааг ургуулан бодож төсөөлөх
		2.1.з. Өгсөн зургаас үндэслэн үйл явдлыг таамаглах	3.1и. Уншсан үлгэр, өгүүллэгийн гол хэсгийн үйл явдлыг хэрхэн өрнөхийг таамаглах	4.1к. Эхийн үйл явдлын төгсгөлийг үндэслэлтэйгээр таамаглах	5.1л. Оньсогын далд утгыг үндэслэлтэй таамаглах

Тайлбар: 5.1и суралцахуйн зорилтын хүрээнд ойлгож уран уншихийн ажлын хуудас боловсруулагдсан ба өмнөх ангийн харгалзах суралцахуйн зорилтуудтай залгамж холбоотой ажлын хуудаснаас эхлэх боломжтой.



Сурагчийн нэр:

Эхэлсэн: он сар өдөр цаг



Унших явцдаа утгыг сайн ойлгохгүй байгаа бол уран унших боломжгүй. Үйл хөдлөл, цаг хугацаа, орон зайн холбоосыг анхааран, утга санаанд тохируулан, зогсолт хийж уншина. Мөн аялга, хурд хэмжээг тохируулан, амьсгалын хуваарилалт, дууны өнгийг зохицуулан, нүүрний хувирал, дохио зангаа ашиглан уншина.

	хоромхон зогсолт
	дунд зэргийн зогсолт
	удаан зогсолт

---	үгийн өргөлт
—	өгүүлбэрийн өргөлт
⤿	хурдац

Эмээг баярлуулсан нь

Уулын нэгэн аманд зуслангийн олон байшин ярайна. Зусланд өдрийн цагаар хүүхдүүд л үлдэнэ. Тэд тоглож наадахаас гадна булгаас ус авах, юм угаах, гэрээ цэвэрлэх, дүүгээ харах, хоол цай бэлтгэх зэрэг ажил ихтэй. Түүнийг нь мэдэх хүн бас ховор.

Энэ өдөр маш халуун байлаа. Саран хоёр том хувин авч, булаг руу ус авахаар явав. Замдаа ганц бие эмгэний суудаг жижиг байшингийн дэргэд хүрч очоод, усны савыг нь өнгийж үзэв. Хов хоосон. Саранг булаг дээр очиход хүүхдүүд ус авцгааж байлаа. - Найзууд аа! Цөмөөрөө ганц бие эмээгийн саванд нэг, нэг хувин ус аваачиж хийе! Их баярлана даа гэж Саран хэлэв. Хүүхдүүд дуугарсангүй. Тэгэхээр нь бас л: -Хөөрхий, их ядарсан эмээ шүү! Хүүхэд байхгүй юм гэнэ лээ! Орой ажлаасаа их л цангачихсан ирэх байх даа гэв. Хүүхдүүд дор бүрдээ өөр өөрийн хувинд ус хутган, дуугүй сууцгаана. - Та нар залхуурч байна уу? Тэгвэл би эмээгийн савыг дүүргэнэ ээ! гэж хэлээд Саран хоёр том хувиндаа ус дүүргэн буцлаа. Хүүхдүүд түүний хойноос харсаар хоцров. Саран гэртээ харьсангүй. Нөгөө хоёр том хувинтай усаа эмээгийн усны саванд юүлээд эргэлээ. -Хүүе ээ! Саран ирж явна. Бас л биднийг... - Харин тиймээ яах вэ? - Туслахгүй бол болохгүй шүү! Саран ирлээ, ирлээ гэгцгээв.

Гэвч энэ удаа тэр юу ч хэлсэнгүй. Найз нөхдөдөө гомдсон янзтай байв. Нөгөө хоёр том хувингаа дахин усаар дүүргэж аваад, хар цагаан дуугүй яваад өглөө. Хараад байсан чинь бас л эмээгийн гадаа очоод усаа юүлж байна.



- Явцгаая! Цөмөөрөө эмээгийнд ус хүргэж өгье! - Тэгье! Ингээд зуслангийн багачууд хувинтай усаа барин, уван цуван явсаар эмээгийн усны савыг дүүргэв.

Удалгүй, эмээ ирлээ. Эмээ байшиндаа оруут хувин, шанагаа авч гарав. Тэгснээ зогтосон: - Үгүй ер өө! Ямар сайн хүн ус зөөж өгөв өө? Ээ буян нь дэлгэр! Ийм их ачтай чинь хэн байдаг билээ? гэх дуулдав. Эмээ хувин шанагаа бариад, ийнхүү ганцаараа ярин зогссоор л байлаа. Эмээ маш их баярласан нь илт байв.

1 Асуултад тохирох хариултыг дугуйлаарай.

1. Хүүхдүүд зуслан дээр хэр их ажилтай байдаг вэ?

а. ажил ихтэй б. бараг ажилгүй в. зүгээр л амардаг

2. Саран, ус авахаар ирэхдээ замдаа юуны талаар мэдэж ирсэн бэ?

а. эмээгийнх эзгүй б. эмээгийн усны сав хоосон в. 2 том сав нь усгүй

3. Саран, эмээд ус зөөж өгье гэхэд хүүхдүүд ямар хариулт өгсөн бэ?

а. дуртай байсан б. дургүй байсан в. хариулт өгөөгүй

4. Хүүхдүүд яагаад эхлээд Сарангийн саналыг хүлээж аваагүй вэ?

а. дургүй нь хүрсэн б. өөрсдөө ус авч байсан в. дурамжхан байсан

5. Саран ямар хүүхэд вэ?

а. шударга, хамтач б. тууштай, тусч в. бялдууч, сониуч

6. Хүүхдүүд эцэст нь яагаад эмээгийн сав руу ус зөөсөн бэ?

а. албан хүчээр хийсэн б. нэгийгээ дуурайсан

в. Сарангийн хийж буй үйлдээс ухаарч, эмээд туслахаар шийдсэн

2 Эхийн утга санаанд тохирох зүйр цэцэн үгсийг олж будаарай.

Бага хэргээс
Их хэргийг үүсгэх

Нөхрөө харж биеэ зас
Сүүдрээ харж бүсээ зас

Саалиа бэлдэхээс өмнө
Саваа бэлд

Усыг нь уувал
Ёсыг нь дага

Хөгшин хүнд өргөмж хэрэгтэй
Залуу хүнд сургамж хэрэгтэй

Дэм дэмэндээ
Дээс эрчиндээ